

**Дөрвөлжин үсгээр түрэг хэлээр бичсэн
нэгэн тамгын тухай**

С. Батхишиг (МУИС)

Турфаны цуглуулгын дотор хадгалагдан үлдсэн нэгэн захидлын тамгын дардас нь одоогоор олдоод байгаа монголын дөрвөлжин бичгээр, түрэг хэлээр бичигдэн үлдсэн цорын ганц дурсгал юм. 1902 оны үед Albert von Le Coq-оор удирдуулсан Германы нэгэн шинжилгээний анги дундад Туркестаны Турфан¹ нутгаас олон зүйл дурсгалт бичиг олсон нь "Турфаны цуглуулга" хэмээн алдаршсан бөгөөд өдгөө Герман улсын шинжлэх ухааны академийн эртний түүх археологийн төв хүрээлэнгийн номын санд хадгалагдаж байна.

Дөрвөлжин бичгээр, түрэг хэлээр бичигдсэн энэ тамгын дардас нь монгол бичгийн захидалд үлдсэн ба уг дурсгал нь Турфаны цуглуулгын дотор T II D 224 дугаараар тэмдэглэгджээ. Энэ дурсгалд археологийн анхны тодорхойлолтыг хийсэн Albert von Le Coq тайландаа: "T II D 224. Өндөр 21,2 см, өргөн 17,8 см. Арван зургаан мөр бүхий энэ дурсгал нь баруун дээд буланд дөрвөлжин бичгийн тамгатай, дээрхи тамгынхаа доод буланд найман дэлбээтэй цэцгийн хэлбэртэй дугираг тамгыг дарсан. Энэ тамгын дөрвөн дүрс нь тодорхой мэдэгдэм²" гэж тэмдэглэжээ.

Энэ дурсгалын судалгааг G.J.Ramstedt [17] эхлэж, эрдэмтэн E.Haenisch [14], L.Ligeti [16], H.Franke [9], А.П.Григорьев [3], Ц.Шагдарсүрэн [19], А.Дамдинсүрэн [4], Цолмон [11], Ё.Жанчив [8] нар өөрсдийн бүтээлдээ оруулж, гол төлөв уг дурсгалын гэрэл зураг болон галигийг нийтлүүлж, товч тайлбаруудыг хийсэн байна. Уг дурсгал нь чухам хэдий үеийнхи болох, хэнээс хэнд, юуны учир явуулсан захидал вэ? гэдэгт эрдэмтдийн үзэл санал нэгдмэл бус байна.

G.J.Ramstedt: "Энэ захидал нь Монголын хаан Элбэгийн хүү Өлзийтөмөрийн захидал ба 1408 онд хамаарна"

¹Одоогийн БНХАУ-ын Шинжаан мужын нутаг. А.Дамдинсүрэн, "Монгол дөрвөлжин бичиг", Улаанбаатар, 1985, 147-р тал

²G.J.Ramstedt, *Mongolische Breife aus Idiqt-Schähri bei Turfan*, SPAW, Berlin, 1909, s. 840

L.Ligeti "Энэ нь 1348 юм уу 1360 онд хамаарах Туглугтөмөрийн захидал болно"

А.Дамдинсүрэн "1326 онд холбогдоно" гээд "Монголын 10-р хаан Есөнтөмөрийн баримт бичиг" гэжээ.

Захидлын тамга нь хэмжээний хувьд бага ч дээрхи санал зөрөөтэй асуудлыг нэгэн мөр болгох хийгээд дөрвөлжин бичиг, түрэг хэлний судлалд чухал хэрэглэгдэхүүн болохын учир тухайлан анхаарч, тойм төдий ажигласнаа өгүүлье.

1. Тамгын дардсан дахи дөрвөлжин бичгээр, түрэг хэлээрхи гурван үгийн тухай

Уг тамгын үгийг дөрвөлжин монгол бичгээр, түрэг хэлээр гурван мөр бичсэн ба хоёрдугаар мөрийнхөө эхэнд дөрвөлжин үсгийн бус хоёр тэмдэгтэй. Тамгын хэмжээг судлаачид тэмдэглээгүй ч захидлын хэмжээгээр баримжаалбал, ойролцоогоор 2.5 см x 2.5 см.

Дөрвөлжин бичгээр бичсэн тамгын үгийг галиглан буулгавал:

1. **oron qud** /t/

2. **luq** /y/

3. **bol sun** буюу **oron qudluq bolsun** гэж түрэг хэлээр бичжээ.

Үүнийг G.J.Ramstedt "Жаргалтай болох болтугай"³, L.Ligeti "Хаан суудал аз жаргалтай байг", Ё.Жанчив "/хаан/ ор өлзийтэй болтугай"⁴ гэж орчуулжээ. "...**qudluq bolsun**" хэмээх хэллэг нь монгол нутаг дахи руни бичгийн дурсгалуудад олонтоо тохиолддогөөс Архангай аймгийн Их-Тамир сумын нутаг дахи "Тайхар чулуу" хэмээх олон зүйлийн бичигт хадны руни бичгийн дурсгалын үгнээ "**qudluq bolzun**" гэсэн хувилбараар тэмдэглэгджээ. Энэ нь:

1. ...öz inencu /...zncu/

Өз инанчу /хүний нэр/

2. cur /cWR/

чур /баатар/

3. baliy barir /BLGaBRiR/

хотод очно⁵

4. **qufluq bolzun** /QWTLWGBWLzWN/ **өлзийтэй болор** гэсэн байгаагаас гадна "Тайхар чулуу"-ны руни бичгийн өөр нэгэн дурсгалд: "...**qut birti**/QWTbirti/" буюу "...өлзий өгөө" гэж тохиолдож байгаа ба мөн Дундговь аймгаас олдсон (Х.Лувсанбалдан анх олсон.) мутрын тамганаа эртний түрэг бичгээр "**qufluq**" буюу "өлзийтэй" хэмээн бичсэн байжээ⁶.

Түүхийн сурвалжид Чингис хааны хоёрдугаар хөвгүүн Цагаадайн улс "Кутлуг" хэмээх бэхлэлт хоттой байсан тухай мэдээ буй⁷. Мөн түрэгийн Капкан хааныг "Кутлуг хаан" хэмээн өргөмжилж байжээ. Үгзүйн үүднээс **qudluq** гэдэг үгийн язгуур нь "**qud**" буюу монгол хэлний өлзий хутаг гэсэн үг юм. "**-luq/-lu**" нөхцөл нь Түрэг хэлэнд *-тай байх* гэсэн утгыг илэрхийлнэ. Монгол бичгийн хэлэнд *-liy /-lig/*, орчин цагийн монгол хэлэнд *"-лаг"* гэсэн хэлбэрээр тохиолдох бөгөөд нэр үгийн идэвхитэй

³G.J.Ramstedt, *Mongolische Breife aus Idiqt-Schähri bei Turfan*, SPAW, Berlin, 1909, s. 845

⁴Ё.Жанчив, *Дөрвөлжин үсгийн монгол дурсгалын судалгаа*, Улаанбаатар, 2000, 4-р тал

⁵ЭБС-ын 3-р ангийн дадлагын тайлан, 2001, /Руни бичгийн дурсгалын зүйл/

⁶Б.Базылхан, *Эртний түрэг бичээстэй мутрын тэмдэг*, Шинжлэх Ухаан Академийн Мэдээ, 1964, №1.

⁷Жувейни, *Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх*, 1-р боть, 271-р тал

язгуур, үндсэнд залгаж, уул үгийн утгаар тодорхойлогдох шинж чанараар элбэг буйг илтгэх тэмдэг нэр бүтдэг ажээ. Жишээ нь: бая(н)+лаг, баатарлаг, сорлог гэх мэт.

Өмнө дурдсан хэдэн баримтаас үзвэл, *кутлуг* хэмээх үг нь бэлгэшээлийн утгаар монгол, түрэг хэлэнд идэвхитэй хэрэглэгдэж байжээ.

Тамгын эхний үг буюу **oron** гэдэг үгийг эрдэмтэд:

1. **oron** (*orun*) - орон газар, орон нутаг⁸
2. **or** - ор суудал, хаан **or**⁹ гэж хоёр янзаар орчуулсан байна.

Oron: энэ үгийн язгуур "**or**" бөгөөд **-on/-un** нь харин түрэг хэлний биед хамаатуулах нөхцөл буюу 2-р биеийн **-чинь** гэсэн нөхцөлийн эртний хэлбэр бололтой. **or** гэдэг үг нь түрэг хэлний биеийн төлөөний үгүүдэд:

- | | |
|--------------------------------|---|
| 1. Benim /миний/ | <i>orum /ор суудал минь/</i> |
| 2. Senin /чиний/ | <i>orun /ор суудал чинь/</i> |
| 3. Onun /түүний/ | <i>orusi /ор суудлыг нь/</i> |
| 4. Bizim /бидний/ | <i>orumuz /бидний ор суудал/</i> |
| 5. Sizin /тэдний/ | <i>orusunuz /тэдний ор суудал/</i> |
| 6. Onlarin /тэдгээрийн/ | <i>orlar /ор суудлууд нь/ гэж хувирдаг.</i> |

"**Oron**" хэмээх энэ үгийг орчин цагийн түрэг хэлний үүднээс "**orun**" гэж галиглах нь илүү зөв мэт санагдавч уг эхэд дөрвөлжин бичгээр "**oron**" хэмээн бичжээ. Энэ нь дундад үеийн түрэг хэлний онцлогийг тусган тэмдэглэснээс үүдэлтэй болов уу.

Өгүүлбэр төгсгөж байгаа "**bolsun**" гэдэг үгийн "**bol**" /бол/ үйл үндсэнд түрэг хэлний захирах хүсэх төлөвийн 2-р бие буюу *chi/sen/* дээр хэрэглэгддэг *-тугай / -түгэй* буюу **-sun** нөхцөлийг залгасан байна. Дундад үеийн монгол хэлэнд **-sun** нөхцөл нь **-su** хэлбэртэй байжээ. Жишээ нь: "МНТ"-ны 64-р зүйлд "**öki yuyusu**" /охин гуйя /=*гуйсугай*// гэж гардаг.

Дээрхи тайлбаруудаас үндэс тулгуур хийж, үгчлэн орчуулбал "*Ор суудал /хаан ор/ тань өлзийтэй байх болтугай*" гэсэн ерөөлийн үг болох бөгөөд "**oron**" гэдэг нь "*нутаг орон*" бус нь "*ор суудал*" гэсэн утгыг зааж байна.

2. Тамгын дардас дахи дөрвөлжин үсгийн бус хоёр тэмдэгийн тухай

Уг тамганы бичээсийн хоёрдугаар мөрөнд дөрвөлжин монгол үсгийн тэмдэгтэд байхгүй хоёр тэмдэгт байгаа ба судлаачид доорхи саналыг дэвшүүлжээ.

G.J.Ramstedt: "...*төвдийн cha* 𐰽 *үсгийг тонгоруулан тавьсан мэт ба үүнтэй адил тэмдэгтүүдийн тамга доод талд нь дарсан байна*" гэсэн байхад БНХАУ-ын судлаач Цолмон "*Монгол тамга сийлмэл*"

хэмээх номдоо: "*Энэ тэмдэг нь Төвдийн цагаан толгойн cha* 𐰽-г *тонгоруулан тавьсан мэт бөгөөд гадаадын зарим эрдэмтэд Цагаагайн үеийн тэмдэг гэж үзэж тэр үеийн зоос бүрд цөм ийм тэмдэг*

⁸А.Дамдинсүрэн, *Монгол дөрвөлжин бичиг*, Улаанбаатар, 1985, 147-р тал

⁹G.Clauson, *An Etymological Dictionary of Pre-Thirteenth Century Turkish*, 1972, 237-р тал, Ё.Жанчив, 2000, 6-р тал, *Древнетюркский словарь*, 372-р тал

байсан гэж үзсэн байна¹⁰ хэмээжээ. Д.Цэрэнсодном, Б.Ринчен нар дөрвөлжин бичгийн тамгын хоёр тэмдэгтийг "...төвд үсгийн маягийн бөгөөд биеэ даасан хэлбэрээр орсон" гэж үзсэн байдаг байна¹¹.

Бидний санахад, тэдгээр тэмдэгтийн утга учрыг тодруулахад тухайн дурсгалын баруун доод буланд дарсан тамгын дардсан дахи тэмдэгтүүдийг харьцуулан үзэх ёстой. Учир нь 1-рт: Уг дурсгалын монгол бичгээр буй захидлын үг хэллэг хийгээд дөрвөлжин үсгийн тамгын утга агуулга нь Ил хаадын захидал болохыг нотолж байна. Уг захидлыг эх бичиг болон руни маягийн үсгийн тамга мөн бусад сурвалжийн мэдээнээс Ил хаадын угсааны Туглугтөмөрийн хулгана жилд хамаарна гэж үзсэн/С.Б/. Тэгвэл, лалын шашны нөлөөнд ихэд автсан Ил хаадын захидлын тамганд бурханы шашныг монголд дэлгэрүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэж байсан төвдийн бичгийг бичжээ гэхэд өөрийн эрхгүй эргэлзээ төрүүлнэ. 2-рт: Т II D224 захидлын баруун доод буланд цэцэг хэлбэрийн нэгэн тамга дарсан бөгөөд цэцгийн голын дугуй дахи тэмдэгт нь дөрвөлжин бичгийн тамгынхаа хоёр тэмдэгтийн нэгэнтэй нь адил бөгөөд түрэгийн бичгийн дурсгалд тохиолдож байна. Тухайлбал, Өвөрхангай аймгийн "Орхон бичээс" хэмээн тэмдэглэгдсэн "bkbä bitidim" буюу "бэг/ноён/-дээ /зориулан/ бичлээ би¹²" гэсэн утга бүхий бичээсийн доторхи хоёр тэмдэгтийн нэг нь эл тамга бөгөөд 6-8 зуун буюу түрэгийн үед хамаарах ажээ.

Харин тамгын хоёрдугаар мөрийн эхний тэмдэгт нь араб хэлний "аллах тэнгэр", "дээд тэнгэр" гэсэн утгатай үг болов уу. Араб хэлний "аллах" гэсэн үгийг араб үсгээр дүйцүүлэн үсэгчлэн буулгавал уг тэмдэгт/үг/ тохирч буй билээ. XIII-XIV зууны үед түрэгүүд араб бичгийг хэрэглээд эхэлсэн тул түрэг хэлээр бичсэн энэ тамгын үгэнд араб үг оруулсан бололтой.

Аллах гэдэг нь нийт Мусулман шашинтнуудын залбиралын үг юм. Монгол нутагт буй араб бичгийн нэгэн дурсгалд энэ үг бичигдсэн байгааг бичлэгийн хэлбэр, уншлагын талаас нь харьцуулж үзлээ. Энэ нь 1973 онд хэл зохиолын хүрээлэнгийн шинжилгээний анги Төв аймгийн Эрдэнэсант сумын нутгаас засмал боржин чулуунаа нэг талд нь дөрвөн мөр араб бичиг, нөгөө талд нь эртний араб тоог нэгэн мөр бичсэн дурсгал олдсоны 4-р мөрний хамгийн сүүлд тохиолдож байгаа ба хэлбэр, бичлэгийн хувьд тохирч байна. Энэ дурсгалын он цагийг хөшөөний ар дээрхи он цагийг үндэслэн 1327 юмуу 1423 он¹³ гэж үздэг байна.

Одоогоор олдоод буй түрэг хэлээр, дөрвөлжин бичгээр бичсэн цорын ганц тамга болох энэ дурсгалыг ажиглан шинжилснээр, дараахи дүгнэлтийг хийж байна.

1. Уг тамгын бичээст буй түрэг хэлээр буй ерөөлийн үгийг дөрвөлжин бичгээр бичжээ. Үүний учир нь:

Нэгд, Дөрвөлжин бичиг нь гадаад үгийг тэмдэглэхэд тухайн хэлний онцлогийг тодорхой гаргаж чадах галиг үсгийн шаардлагыг хангасан үсэг байсантай холбоотой. Энэ онцлогийг нь үндэс болгож, оросын нэрт монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов "Дөрвөлжин бичиг нь олон улсын цагаан толгой байжээ" хэмээн онцолсон байдаг.

¹⁰Цолмон, *Монгол тамга сийлмэл*, Хөх хот, 1996, 22-р тал

¹¹А.Дамдинсүрэн, *Монгол дөрвөлжин бичиг*, Улаанбаатар, 1986, 147-148-р тал

¹²Л.Болд, *Орхон бичгийн дурсгал*, Улаанбаатар, 2000, 256-р тал

¹³Ц.Шагдарсүрэн, *Шинэ олдсон араб бичээстэй хөшөө*, /ШУАМ, №2/ Улаанбаатар, 1978, 66-67-р тал

Хоёрт: Юан гүрний үед монгол бичгийг хэрэглэсээр байсан хэдий ч дөрвөлжин бичгийг төрийн бичиг болгосон байлаа. 1269 онд дөрвөлжин бичгийг хэрэглэх Хубалай хааны зарлиг гарсан юм. Энэ зарлигт: "...Үүнээс хойногшид тамгын бичиг, тархаах бичгийг монгол хэлээр бичээд бус улсын бичгийг хослон бичигтүн..." хэмээжээ. Ил хаадын улс нь Юан гүрний нэгэн хэсэг байлаа. Тэд Их Юан улсын хуулийг дээдлэн хүндэтгэдэг байсан учраас захидлынхаа ерөөлийн үгийг дөрвөлжин бичгээр тэмдэглэжээ.

2. Түрэг хэлээр бичсэний учир нь Захидлын эзэн Туглугтөмөр хаан/1340-1370/-ы тухай "Исламын шашныг хүчтэй дэлгэрүүлж байсан Кебекийн залгамжлагч нь Казан юм. Түүнийг 1340 онд хуйвалдаанаар түлхэн унагааж, засгийн эрхийг түрэгжсэн монголчуудын гарт шилжүүлснээр тус улсын дорнод хэсэгт Түрэгүүд дангаар ноёрхож эхлэв. Иймээс монголчууд Туглугтөмөрийг хаанаар өргөмжилж..."¹⁴ гэх мэтээр Рашид ад-Дин тэмдэглэсэнтэй тохирч байна. Мөн дөрвөлжин бичгийн тамгын дотор араб үсгээр "аллах" хэмээн бичсэн, тамгын үгийг түрэг хэлээр бичсэн зэрэг нь түрэг угсаатанд холбогдохыг харуулж байна.

ТII D 224 хэмээх энэ дурсгалын дөрвөлжин бичгийн энэ багахан дурсгал нь алтай хэлний томоохон бүлэг болох монгол, түрэг хэлний учир холбоог батлах баримт хэрэглэгдэхүүний хүрээг өчүүхэн ч атугай нэмэн баяжуулахын сацуу монгол ил хаадаас түрэг, араб зэрэг исламын шашинтнуудтай шашин соёлын найрсаг харилцаатай байсныг гэрчилж байна. Мөн тамгын дотор тэмдэглэгдсэн араб үг, үсэг нь монгол нутагт буй араб бичгийн дурсгалуудын үг, үсэгтэй хэлбэрийн талаас харьцуулахад чухал хэрэглэгдэхүүн болох юм.

Холбогдох бүтээл


1. Базылхан Б, *Эртний түрэг бичээстэй мутрын тэмдэг*, Шинжлэх Ухааны Академийн Мэдээ, №1, Улаанбаатар, 1964.
2. Болд Л, *Орхон бичгийн дурсгал*, Улаанбаатар, 2000.
3. Григорьев А.П, *Монгольская дипломатика XIII-XIV вв*, Ленинград, 1969.
4. Дамдинсүрэн А, *Монгол дөрвөлжин бичиг*, Улаанбаатар, 1985.
5. Дамдинсүрэн Ц, *Ардчилсан Герман Улсын Шинжлэх Ухааны Академиар орсон тухай тэмдэглэл*, Шинжлэх Ухааны Академийн Мэдээ, №3, Улаанбаатар, 1954.
6. Дашцэдэн Т, *Монголын нууц товчоо/галиг/*, Улаанбаатар, 1985.
7. *Древнетюркский словарь*, Ленинград, 1969.
8. Жанчив Ё, *Дөрвөлжин үсгийн монгол дурсгал*, Улаанбаатар, 2002.
9. Franke H, *Zur Datierung Mongolischen schreiben aus Turfan*, Oriens, 1962, ss. 390-410 /resp.s.407/
10. Cerensodnom D, Taube M, *Die Mongolica der Berliner Turfan sammlung*. Berlin, 1993.
11. Çolmon, *mongol tamga-seyilümel*, Köke qota, 1996.
12. Clauson S.G, *An Etymological Dictionary of Pre-Thirteenth-Century Turkish*, Oxford, 1972.
13. *Information and documentation-Transliteration of Arabic characters into Latin characters*, ISO 233-2/ 1993-08-156.
14. Heanisch E, *Mongolia der Berliner Turfan-Sammlung*.2. Berlin, 1959.
15. Heissig W, *Mongolische Handschriften*, Weisbaden, 1961.
16. Ligeti L, *Monuments Preclassiques. I. 13e et 14e siecles*. MLMC. 2. Budapest, 1972.
17. Ramstedt G.J, *Mongolische Briefe aus Idiqt-Schähri bei Turfan*. SPAW, Berlin, 1909, ss.843-845. /resp.845/
18. Цэрэнсодном Д, *Турфаны дурсгалын 2-р дэвтрийг судалсан байдал*, БНМАУ-ын ШУАМ, Улаанбаатар, 1964, №2, т-104-107.
19. Шагдарсүрэн Ц, *Монгол үсэг зүй*, Улаанбаатар, 1981.
20. Шагдарсүрэн Ц, *Шинэ олдсон араб бичээстэй хөшөө*, /ШУАМ, №2/ Улаанбаатар, 1978.
21. Поппе Н.Н, *Монгольский словарь Мухаддимат ал-адаб I-II*. Москва-Ленинград, 1938.
22. *Эх бичиг судлалын 3-р ангийн дадлагын тайлан*, Улаанбаатар, 2001.

¹⁴Рашид ад-Дин, *Судрын чуулган*, 1311, 124-р тал

ХАВСРАЛТ


Дөрвөлжин бичгийн тамгын дардас нь дотроо араб бичгийн болоод тамга үсгийн дурсгалыг агуулсан ба мөн Т II D 224 дурсгал нь баруун доод буландаа цэцэг хэлбэрийн тамгатай, тамга нь дотроо руни маягийн 8 үсэгтэй.

Е.Нaenisch-ийн гэрэл зургийн хуулбар



Т II D 224 дурсгалын үсгийн галиг /Л.Лигетийн галиг/

1. [Туу]үtemür üge [manu]
2. Qoço-yin cingtemür iduqut-ta arketü daruγ-a
3. [Tü]men-bolad-qiy-a Ötemis-qudluγ-qiy-a
4. ünen erk[eten da]ruγus noyad[ta...]-širi [...]
5. -buyan Turmis-te[m]ür Tükei-qiy-a Kerei akiten
6. tüsimed-te an-e Asen-i Qoço-yin usun-i Yus-qanč-a-[yin]
7. ded bolun metetügei kemen tüsibei bas-a qoriγ qadaγlatuγai
8. [k]ed ber bolju usun-i qoriγ Asen-eče ačinegün angγidaγun Yus-
9. -qanč-a buu yabuγultuγai; mörtен yostan üges-i büsi buu
10. bolγatuγai kemebei ayin kemelügüged [=kemegülüged] bür-ün ked ber bolju
11. Qoço-yin usun-i qoriγ-i Asen-eče ačinegün angγidaγun yabaγulbasu
12. temečebesü qalbasu
13. jriγ-un yosuγar ülü ayiqun aldaqun ta kemen al nišan-tu
14. bičig ögbei qulaγan-a jil junu ačüs
15. sar-a-yin doluγan qaučin-a
16. Berg-čimgen-e бүкүй-түр бичиби



Дөрвөлжин бичгийн тамгын галиг

1. oron qud /ʌ/
2. luq /ʎ/
3. bol sun